



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Аудитын сэдэв батлах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан аудитын сэдвийг үндэслэн 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг боловсруулж, батлагдсан цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын Байнгын хороо, гишүүдэд хүргүүлж байхыг Монгол Улсын Ерөнхий аудиторт үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны  
2019 оны дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНД ГҮЙЦЭТГЭХ АУДИТЫН СЭДЭВ

№	Аудитын сэдэв	Хамрах хүрээ (ТЕЗ)	Улсын Их Хуралд хүргүүлэх хугацаа	Хэлэлцүүлэх Байнгын хорооны нэр
<b>ХУУЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ</b>				
1	Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын телөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	улсын төсвийн ерөнхийлөн захирагч	2020.06.15	Төсвийн байнгын хороо
2	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт	гэрээлэгч талууд	2020.10.01	Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо
3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	бүх төсөв захирагчдын 2019 оны үйл ажиллагаа	2020.06.15	Төсвийн байнгын хороо
4	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн бүх шууд захирагч	-	-
5	Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд аудит хийх	бүх төсөл, хөтөлбөрүүд	-	-
6	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийх	-	-
7	Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн бүх төвлөрүүлэн захирагч	-	-
8	Төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийх	төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжүүд	-	-
9	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх	төсвийн бүх ерөнхийлөн захирагч	-	-
10	Сангийн яамны 2019 оны санхүүгийн тайланд аудит хийх	Сангийн яам	-	-
11	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Сангийн яам	2020.06.10	Төсвийн байнгын хороо
12	Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Сангийн яам	2020.06.10	Төсвийн байнгын хороо

13	Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, сангийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрлын аудит хийх	бүх төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж	-	-
14	Монгол Улсын 2021 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх	Сангийн яам	2020.10.16	Төсвийн байнгын хороо
15	Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны жилийн эцэс, 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийх	Дипломат төлөөлөгчийн газрууд	-	-
16	Газрын тосны салбарт 2014-2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт	“Петрочайнадачин тамсаг Монгол” ХХК-ийн 2 талбайд /2014-2019 оны өртөг нөхөх зардлын баталгаажуулалт/	2020.12.23	Эдийн засгийн байнгын хороо
17	Газрын тосны салбарт 2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт	“Доншен газрын тос Монгол” ХХК-ийн 2019 оны өртөг нөхөх зардлын баталгаажуулалт	2020.06.15	Эдийн засгийн байнгын хороо
18	Газрын тосны салбарт 2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт	хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд	2020.12.23	Эдийн засгийн байнгын хороо
19	Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх	Засгийн газар, Сангийн яам	2020.11.15	Эдийн засгийн байнгын хороо
20	Засгийн газраас ойрын үед хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийх	Засгийн газар, Сангийн яам	2020.12.15	Эдийн засгийн байнгын хороо
21	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, төсвийн ерөнхийлөн захирагч	2020.05.01	Эдийн засгийн байнгын хороо

22	Гүйцэтгэх ажиллагаанд зориулсан хөрөнгийн зарцуулалт	Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар	2020.07.01	Тусгай хяналтын дэд хороонд
23	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах;	Сонгуулийн ерөнхий хороо		Сонгуулийн Ерөнхий хороо
24	Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, сонгуулийн эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах;	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн Ерөнхий хороо
25	Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохoo илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн Ерөнхий хороо
26	Улсын Их Хурлын сонгуулийн тойрот нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн Ерөнхий хороо
27	Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрот нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн тойргийн хороо
28	Улсын Их Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, гишүүнд нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж дүнг олон нийтэд мэдээлэх	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн Ерөнхий хороо
29	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх	сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч		Сонгуулийн тойргийн хороо
30	Өмнөх жилүүдэд хийгдсэн аудитын мөрөөр хийсэн ажлын үр дүнд давтан аудит хийх	холбогдох газрууд	-	-

Сонгууль зохион байгуулах цаглабарт заасан хугацаанд

ОН ДАМЖИЖ ГҮЙЦЭТГЭХ АУДИТ				
31	Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, түүний төслийн үр өгөөжид үзүүлэх нөлөөлөл	Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн Яам, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс МГЛ” ХХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, “Оюутолгой” ХХК	2020.05.15	Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо